

# ХААН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

No 1

Улаанбаатар хот

### Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтад хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын 11 тоот тогтоол;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

- 1. ТОГТООХ НЬ: "ХААН Банк" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг олон нийтэд гаргасан нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 191,219,800 (нэг зуун ерэн нэгэн сая хоёр зуун арван есөн мянга найман зуу) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 1,912,198,000.00 (нэг тэрбум есөн зуун арван хоёр сая нэг зуун ерэн найман мянга) ширхэг гаргасан энгийн хувьцаатай буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 191,219,800,000.00 (нэг зуун ерэн нэгэн тэрбум хоёр зуун арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр тогтоосугай.
- 2. ТОГТООХ НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

хурлын дарга З Дого вел т.дарьбум



## ХААН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

Nº 2

Улаанбаатар хот

### ХААН Банкны Дүрмийг батлах тухай

**ҮНДЭСЛЭЛ:** Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтад хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар банкны дүрэм батлах, уг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

- 1. **ТОГТООХ НЬ:** "ХААН Банк" ХК-ийн Дүрмийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
- 2. **ТОГТООХ НЬ:** Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах, Банкны дүрмийг бүртгүүлэх зэрэг шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д олгосугай.
- 3. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

хурлын дарга В Вог вил т.дарьбум



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

No3

Улаанбаатар хот

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

**ҮНДЭСЛЭЛ:** Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтад хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** "ХААН Банк" ХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

- 1. **ТОГТООХ НЬ:** Дараах нэр дэвшигчдийг "ХААН Банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар томилсугай:
  - 1.1. Ноён Цагаач овогтой Баатарсайхан
  - 1.2. Хатагтай Дашдаваа овогтой Хулан
  - 1.3. Ноён Харада Ясүнари
  - 1.4. Ноён Иший Кисабүро
  - 1.5. Ноён Батболд овогтой Амарсанаа
  - 1.6. Ноён Жон Ло
- 2. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон банкны дүрмийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
- 3. ТОГТООХ НЬ: Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах болон шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д олгосугай.
- 4. ТОГТООХ НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

хурлын дарга Сог, вест. дарьбум



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

Nº 4

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон томилох тухай

**ҮНДЭСЛЭЛ:** Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтад хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** "ХААН Банк" ХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

- 1. **ТОГТООХ НЬ:** Дараах нэр дэвшигчдийг "ХААН Банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар томилсугай:
  - 1.1. Хатагтай Түдэв овогтой Дарьбум
  - 1.2. Ноён Ханс Аарт Йонгеяанс
  - 1.3. Ноён Амарбаясгалан овогтой Тамир
- **2. ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон банкны дүрмийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
- 3. **ТОГТООХ НЬ:** Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах болон шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д олгосугай.
- 4. ТОГТООХ НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

хурлын дарга Дог вест. да

EAHK